



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/1038

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 96 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг нь бохир усны төвийн шугамд холбогдож цаашид бохир усны шахуургын барилга байгууламжийг ашиглахгүй болсонтой холбогдуулан тус газрын эзэмшил бүхий газарт байрлалтай “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй 1,534,413.00 (нэг сая таван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун арван гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй хавсралтад заасан бохирын станцын барилга, цахилгааны тоног төхөөрөмжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ (Д.Алтангэрэл)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар П.Хадбаатарт даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 08 дугаар сарын 29 ны
 өдрийн 41/08 дугаар захиралжийн
 хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт	Эзэмшигч байгууллага
1	Барилга КНС /бохирын станцын барилга/	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	472,500.00	472,500.00	-	ОСНААУГ-ын техникийн комиссын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн акт	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
2	КНС хучиний самбар ЕСО	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	717,477.00	717,477.00	-		
3	КНС хучиний самбар 400А	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	344,436.00	344,436.00	-		
Дүн				1,534,413.00	1,534,413.00	-		

(төгрөгөөр)